Төрийн нарийн бичгийн даргын
2023 оны 03 дугаар сарын ..09..-ний өдрийн
07/53..... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн хяналт шалгалтын тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Салбарын хяналтын газар |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
| Боловсрол, шинжлэх ухааны салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-6 |
| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдөр 8 цаг | 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго**:**
Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн
31 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Төрийн хяналт шалгалтын тухай хууль |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |
| Байгууллагын нэр: Боловсрол, шинжлэх ухааны яам | Нэгжийн нэр: Салбарын хяналтын газар |
| Албан тушаалын нэр: Боловсрол, шинжлэх ухааны салбарын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн | Албан тушаалын ангилал, зэрэглэл: Дэс түшмэл, ТЗ-6 |
| Ажлын цаг: Ажлын өдөр 8 цаг | Ажлын байрны албан ёсны байршил: 14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**
**1.Боловсрол, шинжлэх ухааны салбарт төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулах, хууль тогтоомжийн үндсэн дээр хэрэгжүүлэх;**
**2.Хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, зөрчил дутагдлыг таслан зогсоох;**
**3.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх орон нутгийн нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;**
4.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулах, тайлагнах;
5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Салбарын хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналтын хуудсыг шинэчлэх, хяналт шалгалт хийж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хөтлөх; | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Г, Х |
| | 2.Бүртгэл мэдээллийн сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулах; | Салбарын хяналт шалгалтын ажлыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг дээшлүүлсэн байна. | Г, Х |
| | 3.Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартыг хэрхэн хэрэгжүүлж байгааг судлан нэгтгэж, боловсронгуй болгох саналаа хүргүүлэх; | Хяналт шалгалт хийх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна. | Г |
| | 4.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 5.Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулахад чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээлэл, зөвлөмжөөр хангах; | Аж ахуйн нэгж байгууллагын хуулийн сахин мөрдөлт сайжирсан байна. | Г |
| | 6.Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах; | Журмын хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 7.Орон нутгийн улсын байцаагчийн | Стандартын | Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| | үйлдсэн эрх зүйн баримт бичиг, стандартын мөрдөлт, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх; | шаардлага хангасан байна. | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Улсын байцаагчийн хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх; | Хяналт шалгалт бүрэн гүйцэд хийгдсэн байна. | Г |
| | 2.Ноцтой осол, аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, тохиолдол болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 3.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж, улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 4.Улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 5.Улсын байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 6.Холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, дүгнэлт гаргах; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г |
| | 7.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах; | Хяналт шалгалт бүрэн гүйцэд хийгдсэн байна. | Г, Х |
| | 8.Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг зохих хууль журмын дагуу | Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх. | хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх орон нутгийн нэгж, улсын байцаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан саналаа танилцуулах; | Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ. | Г |
| | 2.Байгууллагын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу болон бусад арга хэлбэрээр улсын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах; | | Г |
| | 3.Хяналт шалгалтын гүйцэтгэл, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гарын авлага, зөвлөмж, мэдээлэл боловсруулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах. | | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох албан тушаалтантай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах; | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Х, Г |
| | 2.Албан тушаалын чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах; | Хугацаанд чанартай тайлагнасан байна. | Г |
| | 3.Яамны удирдлага, бусад нэгжид ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл, судалгаа, баримт бичгийг шуурхай, чанартай гаргаж өгөх; | Мэдээ мэдээллийг бодит үнэн зөв гаргасан байна. | Г |
| | 4.Албан тушаалын чиг үүрэгт хамаарах албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж, барагдуулах, мэдээ мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах; | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна. | Г, Т |
| | 5.Төрийн бус байгууллага, иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх. | Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна. | Т, Г, Х |
| | 1.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон стандарчиллын техникийн хороонд ажиллах; | Улсын байцаагчийн мэдлэг, ажлын чадавх дээшилнэ. | Г |
| | 2.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг | ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж, ёс | Г |

| | | | |
|---|---|---|---|
| 5 дугаар зорилтын хүрээнд | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг, баримтлан ажиллах; | зүйн зөрчилгүй ажилласан байна. | |
| | 3.Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх орон нутгийн нэгж, улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлүүлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Г |
| | 4.Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцох; | Хамтын ажиллагаа өргөжсөн байна. | Г |
| | 5.Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна. | Г |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | -боловсролын шинжлэх ухаан /0111/;<br>-багш, мэргэжлийн /0114/;<br>-эрх зүй /0421/. | |
| Мэргэшил | Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | |
| | Дүн шинжилгээ хийх | - салбарын хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх;<br>- цахим хяналтын систем дэх хяналт шалгалтын мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;<br>- хяналтын объектуудад эрсдэлийн үнэлгээний дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;<br>- хариуцсан хяналтын салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- хариуцсан хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;<br>- бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд |

| | | |
|---|---|---|
| | | захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах;<br>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, холбоотой арга замыг оновчтой тодорхойлж, хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах;<br>- гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад; |
| Ур чадвар | Багаар ажиллах | - өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх;<br>- бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх;<br>- аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;<br>- аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах<br>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- бусад. |
| | Бусад | - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;<br>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах;<br>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;<br>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;<br>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;<br>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;<br>- албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах, нууцыг хадгалах;<br>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх. |

| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
|---|---|
| <u>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u><br>Салбарын хяналтын газрын дарга. | |
| <u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> | <u>Бусад харилцах субъект</u>:<br>- Засгийн газрын хэрэг эрхлэх газар;<br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага;<br>- Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага. |

| V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br>................................ / /<br>2023 оны 03 сарын 09 ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 23 0201<br>Дугаар: 031 |

| VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН: |
|---|
| Байгууллагын нэр:<br>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ<br>Шийдвэрийн огноо: 2023.03.09<br>Дугаар: Б/53<br>(тамга/тэмдэг)<br>ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ................................ /Л.ЦЭДЭВСҮРЭН/<br>2023 оны ... дугаар сарын ... -ны өдөр |